



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/501

Мандалговь

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс ажиллуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Эрдмийн далай цогцолбор сургуулийн барилгын сантехникийн засварын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|-----------------------|---------------|---|
| Комиссын дарга: | Н.Эрдэнэ-Очир | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга) |
| Нарийн бичгийн дарга: | О.Мөнхзул | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн) |
| Гишүүд: | Н.Эрдэнэбат | (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн) |
| | Г.Мягмарсүрэн | ("Эрчим төсөл" ХХК-ийн инженер) |
| | Э.Дашням | ("Ган-Илч" ХХК-ийн ерөнхий инженер) |
| | Т.Туяамандах | (Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн захирал) |
| | П.Алтанчимэг | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга) |

Хоёр. Засварын ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлт гарган, архивт хүлээлгэн өгч мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг комисс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

488010536